

Аудитын код: САГ-2018/98/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай
холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Аудитор Н.Золзаяа
Утас: 260512 Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Дундманхайдай аудит ХХК
Аудитор Ж.Бямбажав
Утас: 11-325262 Цахим хаяг: byambaahunnu@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.5	Дотоод хяналт.....	5
2.6	Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:.....	6
2.9.2	Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:	7
2.9.3	Аудитын явцад дараах материаллаг алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:	8
2.9.4	Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:.....	11
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	11
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	12
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	12
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	14
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	20
4.1	Аудит хийгдсэн Санхүү байдлын тайлан	20
4.2	Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	21
4.3	Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.4	Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан	23

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Ажлын газрын IV байр
Утас: 76-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/731
танай _____ -ны № _____ -т

БАТЛАН ХАМГААЛАХ АЖ
ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ С.БААСАНХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаас үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томсохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нэтлөх зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

C:\10.10.10.27\khq_khereg\newsan_Bich\2018\06\554660.docx

071148

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын гол асуудал

"Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд:

2017 оны байгууллагын зорилтот түвшин, төлөвлөгөө болон үйл ажиллагааны зардал, худалдан авалтын төлөвлөгөө батлуулаагүй, тайлант онд худалдан авсан 39.9 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар бүртгэсэн. Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль, Цэргийн Төв Эмнэлгийн хэрэгцээт нийт 53 багцын эм, орсох боох материал нийлүүлэх тендерийн бичиг баримт зөрчилтэй болон зарим багцын төсөвт өртгийг хэтрүүлсэн, он дамжсан нийт 215.1 сая төгрөгийн өглөг, 95.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг нийт 266.4 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

"Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР



610.10.13.20@Ichig_Khrcog/Yawzan_Ekhhg/2015/0315/AV660.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ийн /цаашид Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл гэх/ 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн захирал С.Баасанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн орлого, зардлыг төсөвлөх, өглөг авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн удирдлага санхүүгийн тайлангаа НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 8-наас 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 13-нд эцэслэн баталгаажуулж, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн удирдлагад



хүргүүлэхээр төлөвлөн, Дундманхайдай аудит ХХК-ийн аудитор Ж.Бямбажав, М.Мөнхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 55 дугаар албан бичгээр Дундманхайдай аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь санхүүгийн үйл ажиллагаандаа Батлан хамгаалахын тухай, Төрийн нууцын тухай, Төсвийн тухай хууль, Компанийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хуулиуд болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, бусад холбогдох хуулиуд зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.3

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2013 оны 107 дугаар тогтоолын 6,2 дахь заалтыг үндэслэн “Монгол цэрэг бүтээн байгуулалтад” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БХЯ-ны харьяа ТӨААТҮГ болон үүсгэн байгуулагдсан байна.

2014 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж байгууллагуудыг үр ашигтай ажиллуулах, нэгдмэл удирдлагаар хангах зорилгоор “Транссэргэлт” ААТТӨҮГ болон “Батпромимпекс” ХХК-ийг тус газартай нэгтгэн өргөтгөн зохион байгуулсан.

Тус нэгдэл байгуулагдсанаар БХЯ-ны харьяанд үйл ажиллагаа явуулж байсан зарим аж ахуйн нэгж байгууллагуудыг нэгдмэл удирдлага, зохион байгуулалтад оруулсан, цаашид цэргийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, улс орны бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн үйл ажиллагаа нь БХЯ-ны харьяа төрийн өмчит үйлдвэрийн газруудыг менежментийн нэгдсэн удирдлагаар хангах, батлан хамгаалах аж үйлдвэрийн чадавхийг дээшлүүлэх, гадаад, дотоод зах зээлд зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн худалдаа, үйлчилгээ эрхлэх, галт хэрэглэлийн эргэлтийг зохион байгуулах, батлан хамгаалах салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг хангахад чиглэгдэж байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг экспортлох, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

БХЯ-ны захиалга, даалгавраар хийж гүйцэтгэсэн болон зуучилсан ажил, үйлчилгээний нийт орлогын 5 хүртэл хувийг байгууллагынхаа үйл ажиллагаанд захиран зарцуулдаг.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан..

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн гол шалгуур болголоо.

Аудитаар Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн

01 ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн ТӨААТҮГ-ын захиралын 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/70 дугаар тушаалаар баталсан санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллан, Ординат ХХК-ийн "Веница" програмыг хэрэглэж санхүүгийн тайлангаа бэлтгэн тайлагнаж байна.

Уг програм нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн байна.

Тайлангийн хугацаанд банкны харилцах дансны гүйлгээний санхүүгийн баримтанд нэгдүгээр гарын үсгийг Ерөнхий захирал хурандаа Б.Коля 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл, улмаар байгууллагын ерөнхий захирлаар бэлтгэл хошууч генерал Сүрэнгийн Баасанхүү Батлан хамгаалахын сайдын 2017 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн Б/61 тоот тушаалаар томилогдон ажиллаж байна. Тус газрын ерөнхий нягтлан бодогчоор Б.Мөнхсүх 2017 оны 01 дүгээр сараас 07 дугаар сар хүртэл, Батбаярын Оюундэлгэр БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн Б/123 тоот тушаалаар ерөнхий нягтлан бодогчоор томилогдон хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.


Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программ хэрэглэн НББ-ийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь хэсгийг үндэслэн Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар баталсан "санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу тайлагнасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Тус газар дотоод хяналтын нэгж байхгүй БХЯ-с хэрэгжүүлэн ажилладаг 2017 онд дотоод хяналтын үйл ажиллагаа хийгдээгүй байна.



Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын захиралын 2017 оны 10 дугаар сарын 18-ны А/26 дугаар тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулан ажиллаж эхэлсэн байна.

2.6 Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 онд орлого зардлын төлөвлөгөө батлагдаагүй, гүйцэтгэлээр 857.3 сая төгрөг орлого төвлөрүүлж, 421.3 сая төгрөг зарцуулж 436.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2017 онд өмнөх оноос нийт орлого 719.5 сая төгрөгөөр, зардал 1130.3 сая төгрөгөөр буурч нийт ашгийн хэмжээ 364.1 сая төгрөгөөр өссөн байна.

Тус байгууллагын 2017 онд зорилтот түвшин болон төсөв, төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөө батлагдаагүй нь үйл ажиллагааг хянах боломжгүй, мөнгөн хөрөнгийн зарцуулалт урсгалаар явагдсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn сайтнаас авч үзлээ. Шилэн дансны сайтад байгууллагын цалингаас зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан хагас жилээр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан.

2017 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитаар мэдээлбэл зохих 178 мэдээллээс 140 мэдээллийг бүрэн оруулж, нийт 78,6 хувьтай байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 16 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 19 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Байгууллагын орлого, зарлагын гүйцэтгэлийн үр дүн, цалингийн сан түүний гүйцэтгэл, байгууллага хүмүүстэй хийх төлбөр тооцоо, хэргийн цахид болон бусад мөнгөний дансны гүйлгээ, авлага, өглөг, хөрөнгө материал, худалдан авалтын тооцоо бодолт, худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилт, алхан болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт зэргийг холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай тулган

шалгахад дараах эрсдлүүд илэрсэн болно. 2017 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр:

1. Авлага : 7 байгууллагаас авах 2005-2013 онуудад үүссэн 52.8 сая төгрөг, 15 хувь хүнээс авах 2004-2013 онуудад үүссэн 42.5 сая төгрөг нийт 95.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, насчилт өндөртэй авлага барагдаагүй байна.
2. Өглөг : 17 байгууллагад өгөх 189.0 сая төгрөг, 5 хүнд өгөх 26.1 сая төгрөг нийт 215.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

2014 онд Засгийн газрын 63 дугаар тогтоолоор “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ-ын бүтцэд “Монгол цэрэг констракшн”, “Транссэргэлт” ТӨААТҮГ-ууд болон “Батпромимпекс” ХХК-ийг нэгтгэж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийсэнтэй холбоотойгоор баланс нэгтгэхэд 95.3 сая төгрөгийн байгууллага хүмүүстэй холбоотой авлага, 153.6 сая төгрөгийн өр төлбөр шилжин ирсэн нь барагдахгүй байх эрсдлийг үүсгэж байна.

Мөн дээрх шийдвэртэй холбоотой богино хугацааны хөрөнгө оруулалт дансанд бүртгэлтэй /Монгол цэрэг жуулчин компани, Хаан тайж амралтын хувьцаатай холбоотой/ 161.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн нь бодитоор оршин байхгүй байна.


3. Бараа материал, хангамж, шатахууныг эд хариуцагчийн тайланд орлого, зарлагыг бүртгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, дансны бичилтийг буруу бүртгэснээс байгууллагын үр дүнг бууруулах, бараа материалын үлдэгдэл буруу илэрхийлэгдэх эрсдэл өндөр байна.
4. Байгууллагын дансанд бүртгэлтэй хөдлөх буюу үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлсний орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлээгүй байна.
5. Үйл ажиллагааны зардлын төлөвлөлт тооцоолол хангалтгүй, зарим нэр төрлийн зардал төлөвлөснөөс хэтрэлттэй байна.
6. Зорилтот түвшин, худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2017 онд батлуулж, мөрдөж бараа ажил үйлчилгээний худалдан авах ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангахгүй байна.
7. Шилэн дансны мэдээллийн санд зардлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл тайлбарыг бүрэн оруулж тайлагнах асуудал шаардлагын хэмжээнд хүрээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр асуудлуудыг аудитаар илэрсэн зөрчлүүд түүнийг шийдвэрлэсэн байдал хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

2.9.2 Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Тайлант хугацаанд тус газарт дараах гол гүйлгээ гарсан байна. Үүнд:

- Бөртэ ТӨҮГ-т БХЯ-д нийт 360.4 сая төгрөгийн түр зээл олгосон.
- 2016 оны 05 сарын 16-ний өдрийн 4345 тоотор Анхан шатны шүүхийн



шийдвэрээр В.Лувсанпүрэвт 19.3 сая төгрөг шилжүүлсэн.

- Хаан банкнаас Тоног төхөөрөмжийн угсралтын зардалд 20.0 сая төгрөг бэлнээр татан авсан.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл нь 2017 оны жилийн эцсийн тайлангаар 2,074.9 сая төгрөгийн хөрөнгөтэй байна. Үндсэн хөрөнгийн дансанд доорх өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- БХСайдын 2017 оны 9-р сарын 07-ны өдрийн А/266 дугаар тушаалаар 15.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг БХЯ-ны Үйлчилгээ аж ахуйн хэлтэст, БХИС-д балансаас балансад шилжүүлсэн.
- БХСайдын 2017 оны 12-р сарын 15-ны өдрийн А/358 дугаар тушаалаар 49.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ЗХЖШ-т балансаас балансад шилжүүлсэн.
- БХСайдын 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн Н/18 дугаар тушаалаар 78 нэр төрлийн 55.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.


Мөн Батлан хамгаалахын сайдын тушаалаар дараахь үндсэн хөрөнгүүдийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан.

- “М”объекттой холбоотой БХСайдын 2017 оны 11-р сарын А/316 дугаар тушаалын дагуу 163.5 сая төгрөгийн 2 орон сууц, автомашины зогсоолын хамт хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн.
- “Цэвэр ус төсөл”-ийн хүрээнд БХСайдын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/376 дугаар тушаалаар цэвэр усны үйлдвэрийн барилгын засвар болон гүний худгийн хамт 339.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн капиталжуулалт болон гүний худгийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны болон бусад орлого, бараа материал, тээвэр шатахуун, авлага болон өр төлбөр, цалин хөлс, татвар хураамж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 80 хувь, мөнгөн хөрөнгийн 75 хувь, бараа материалын 60 хувь, зардлын 60 хувь, авлага, өглөгийн 70 хувь, нийт хөрөнгийн 85 хувийг тус тус эзэлж байна.

2.9.3 Аудитын явцад дараах материаллаг алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:



1. 2017 оны байгууллагын зорилтот түвшин болон төлөвлөгөө, үйл ажиллагааны зардал, худалдан авалтын төлөвлөгөө тус тус батлагдаагүйгээс үр ашиг тооцох, зардлаа хянах бололцоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны эхэнд байгууллагын зорилтот түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөг батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байх талаар зөвлөмж өгөв.

2. Тайлант онд худалдан авсан 39.9 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар бүртгэсэн нь Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар”-т “бараа материалыг худалдан авсан үед Дт-Хангамжийн материал, Кт- Мөнгөн хөрөнгө/ дансны өглөг” гэж бүртгэх буюу “Иж бүрэн байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дутагдлыг дахин давтан гаргахгүй ажиллахыг зөвлөмж өгөв.

3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, засвартай баримтаар 0.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй буюу “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ тайланд тусгахгүй байх талаар зөвлөмж өгөв.

4. Байгууллагын кассаас 11.0 сая төгрөгийг бэлнээр зээл өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг зориулалтын дагуу зарцуулж байх талаарх зөвлөмж өгөв.

5. Цайны газрын гэрээний дагуу түрээсийн орлогын 5.0 сая төгрөгийг аккруэл сууриар бүртгээгүй, 10.6 сая төгрөгийн түрээсийн орлогоос төсөвт 2.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй нь Төрийн өмчийн хорооны “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” тогтоолын 1.в-д зааснаар “Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлснээс олсон орлогын 20 хувийг төрийн өмчийн хорооны төрийн сангийн дансанд сар бүр төвлөрүүлж, улирал жилийн эцэст Төрийн өмчийн хороотой тооцоо нийлж, акт үйлдэж байх” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоогохоор шийдвэрлэв.



6. Иргэдээс бараа материал худалдан авсаны үнийг шилжүүлэхдээ нийт 4.8 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 27.2-д “Албан татвар төлөгч энэ хуулийн 8.1.6-д заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.2.2-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулан төлж, албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах татварын тооцоо хийнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг залруулав.

7. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 0.3 сая төгрөгийн хөрөнгийг ангилал буруу бүртгэсэн нь Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалын хавсралт “Аж ахуй нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-т үндсэн хөрөнгийг мөнгөөр буюу дараа тооцоогоор худалдан авах үед: Дт- Үндсэн хөрөнгө, Кт – Мөнгөн хөрөнгө / дансны өглөг гэж бүртгэх буюу “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг аудитын явцад залруулав.

8. Бусад орлого 48.9 сая төгрөгийг үйл ажилагч орлогыг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй бүртгэсэн нь Үнэн зөв байдал: аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулга хийв.

9. Тайлант онд зочин төлөөлөгч хүлээн авахад зориулж батлагдсан төсвөөс 1.1 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган, үр ашигтай зарцуулж байх талаар зөвлөмж өгөв.

10. Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль, Цэргийн Төв Эмнэлгийн хэрэгцээт нийт 53 багцын эм, ороох боох материал нийлүүлэх тендерийн Үнэлгээний хороо тендерийн бичиг баримт боловсруулан захиалагчаар батлуулсан ч худалдан авалтын төлөвлөгөөний төсөвт өртгийг захиалагчаар 2017 оны 02 дугаар сарын 26-ны өдөр буюу тендер нээх хугацаанаас 2 хоногийн өмнө баталгаажуулсан нь худалдан авах ажиллагааны журамтай нийцээгүй, захиалагч, нийлүүлэгчийн албан бичгийн он сар өдөр зөрчилтэй, шууд гэрээ байгуулах эрх олгосон 3 төрлийн эмийн багц нийт үнээр 1,7 сая төгрөгөөр төсөвт өртгөөсөө илүү үнээр шалгаруулсан. Гэрээ дүгнэсэн акт ирүүлээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна”, 46.1.4-д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан төрийн шилдгийн төлөвлөж зохион байгуулах”, 46.1.5.”тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх”, 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

11.45.2 сая Агаарын цэргийн радиолакацийн сэлбэг худалдан авах ажиллагааны төгрөгийг иргэдээс шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-т дэх Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах, худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж байх талаар зөвлөмж өгөв.

12.Он дамжсан нийт 215.1 сая төгрөгийн өглөг, 95.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь НББ-ийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуримтлагдсан болон тайлант онд үүссэн авлагыг даруй барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж хүргүүлэв.

2.9.4 Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

1.Тайлант хугацаанд байгууллагаас төлөх 0.2 сая төгрөгийн НДШ-ийг тооцооллын алдаа гаргаж дутуу тайлагнасан нь: “*Үнэн зөв байдал*” батламж мэдэгдэл: “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.Ажиллагсдын цалинг тооцож олгохдоо 0,1 сая төгрөгийн ХХОАТ-ыг илүү тооцож авсан нь “*Үнэн зөв байдал*” аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитаар илэрсэн алдаануудаас материаллаг бус дүнтэй болон мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй зүйлсийг залруулаагүй бөгөөд Менежментийн захидалд зөвлөмж өгсөн.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тус компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцал цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан урьдчилж гарсан тооцоо болон урьдчилж орсон орлого дансдын үлдэгдэл, мах, хүнсний тендерийн гүйцэтгэлийн материал, хэрэгжиж дуусаагүй худалдан авалт, төсөл хөтөлбөрүүдийн үлдэгдлийн тооцоо зэргийг гүйцээж мөшгин шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх болно.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 970.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс аудитын явцад 655.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 2.1 сая төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож, 1.7 сая төгрөгт албан шаардлага өгч, 266.4 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитыг “Оюу эрдэм аудит” ХХК нь хэрэгжүүлсэн бөгөөд аудитаар 5 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж хэрэгжүүлэн, 3 зөвлөмж дутуу 40 хувийн биелэлттэй байна. Үүнд:

1. Авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулах,
2. Үндсэн хөрөнгүүдийг балансаас балансд шилжүүлэх,
3. Санхүүгийн тайланд бодитоор оршин байхгүй хөрөнгийг шийдвэрдэх асуудлын дутуу биелэлттэй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 421.3 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж ирүүлэхийг Менежментийн захидлаар хүргүүллээ.

Аудитаар **Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн** 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд материаллаг дүн бүхий болон материаллаг бус мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй ч шинж чанар өндөртэй доорх зөрчил дутагдал гарсан учир аудиторын гэрчилгээнд хязгаарлалтай дүгнэлт өгсөн. Үүнд:

- 2017 оны байгууллагын зорилтот түвшин болон төлөвлөгөө, үйл ажиллагааны зардал, худалдан авалтын төлөвлөгөө тус тус батлагдаагүйгээс үр ашиг тооцох, зардлаа хянах бололцоогүй байна.
- Тайлант онд худалдан авсан 39.9 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар бүртгэсэн нь Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар”-ыг зөрчсөн буюу “Иж бүрэн байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль, Цэргийн Төв Эмнэлгийн хэрэгцээт нийт 53 багцын эм, ороох боох материал нийлүүлэх тендерийн Үнэлгээний хороо тендерийн бичиг баримт боловсруулан захиалагчаар батлуулсан ч худалдан авалтын төлөвлөгөөний төсөвт өртгийг захиалагчаар 2017 оны 02 дугаар сарын 26-ний өдөр буюу тендер нээх хугацаанаас 2 хоногийн өмнө баталгаажуулсан, захиалагч, нийлүүлэгчийн албан бичгийн он сар өдөр

зөрчилтэй, шууд гэрээ байгуулах эрх олгосон 3 эмийн багц төсөвт өртгөөсөө илүү үнээр шалгаруулсан, гэрээнд хяналт тавих, гэрээг дүгнэсэн актууд ирүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна”, 46.1.4-д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.5.”тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх;” 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

- Он дамжсан нийт 215.1 сая төгрөгийн өглөг, 95.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь: НББ-ийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй буюу бидний тогтоосон материаллаг түвшингээс хэтэрч байна

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлийн ТӨААТҮГ нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



Асуудал 1**Худалдан авах ажиллагаа
төлөвлөлт****Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд нууцын зэрэгтэй гэсэн шалтгаанаар нийт 45.2 сая төгрөгийн бараа материалыг иргэдээс шууд худалдан авалт хийсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-т дэх Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно гэсэнтэй нийцээгүй байна.

2017 оны байгууллагын зорилтот түвшин буюу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө үйл ажиллагааны зардал болон худалдан авалтын төлөвлөгөө батлуулаагүй нь үр ашиг тооцох болон зардлаа хянах бололцоогүй байна.

Эрсдэлүүд

-Байгууллагын үйл ажиллагаанд хууль, эрх зүйн актууд зөрчигдөх, санхүүгийн тайлан гүйцэтгэлийн үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан гэрээнд заагдсан ажил үйлчилгээний өртөг, зардлыг бодитой тооцож, гэрээний хугацаа дуусгавар болсон үед нь гэрээний биелэлтийг тооцож байх, биелэлтийг 2018 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитийн зөвлөмжийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 2

Авлага өглөг

ҮАГ-ын ажиглалт

Он дамжсан нийт 215.1 сая төгрөгийн өглөг, 95.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь: НББ-ийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй байна

Эрсдэлүүд

Байгууллагын үйл ажиллагаа доголдох эрсдэл үүсэх

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын зөвлөмж

Авлага өглөгийг барагдуулах зөвлөмж өгөв. Биелэлтийг 2018 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Асуудал 1

Мөнгөн хөрөнгө

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын кассаас 11.0 сая төгрөгийг бэлнээр зээл өгсөн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна

Эрсдэлүүд

Байгууллагын өмч хөрөнгө үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэх

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын зөвлөмж

Орлогыг зориулалтын дагуу зарцуулж байх талаарх зөвлөмж өгөв. Хуулийн заалтыг мөрдөн ажиллах, биелэлтийг 2018 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ



Асуудал 2

Тэргүүлэх ач холбогдол №2

Зардал

ҮАГ-ын ажиглалт

ҮАГ-ын зөвлөмж

Тайлант онд зочин төлөөлөгч хүлээн авах батлагдсан төсвөөс 1.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай зарцуулж байх талаар зөвлөмж өгөв Биелэлтийг 2018 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Үйлчлүүлэгчийн хариу

Зардлын дүн өсөж үр ашиггүй зарцуулалт гарах үйл ажиллагаа доголдох эрсдэл үүсэх

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана.



Асуудал 3

Бараа материал

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд худалдан авсан 39.9 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар бүртгэсэн нь Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар”-ыг зөрчсөн буюу “Иж бүрэн байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа.

Эрсдэлүүд

Байгууллагын өмч хөрөнгө үр ашиггүй зарцуулах,үлдэгдэл буруу илэрхийлэгдэх эрсдэл үүсэх

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалыг орлого зардлыг дансд тусган ажиллах талаар зөвлөмж өгөв Биелэлтийг 2018 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я. Самбууням

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Ж.Бямбажав





4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛ
ТӨААТҮГ

2017 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
ХӨРӨНГӨ	1,361,805,386.59	2,600,061,557.24
Эргэлтийн хөрөнгө	587,365,542.38	1,415,103,694.72
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	455,532,785.46	604,726,657.13
Дансны авлага	52,876,424.83	60,674,364.83
Татвар, НДШ-ийн авлага	390,422.04	-
Бусад авлага	44,524,823.05	42,524,823.05
Бараа материал	24,129,217.00	24,074,561.91
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,911,870.00	683,103,287.80
Эргэлтийн хөрөнгийн дүн	587,365,542.38	1,415,103,694.72
Эргэлтийн бус хөрөнгө	774,439,844.21	1,184,957,862.52
Үндсэн хөрөнгө	612,285,085.30	1,023,393,830.88
Биет бус хөрөнгө	1,004,758.91	414,031.64
Урт хугацаат хөрөнгө оруулалт	161,150,000.00	161,150,000.00
Эргэлийн бус хөрөнгийн дүн	774,439,844.21	1,184,957,862.52
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,361,805,386.59	2,600,061,557.24
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр	647,037,907.91	1,502,013,462.49
Дансны өглөг	292,423,193.46	215,116,322.66
Цалингийн өглөг	10,373,192.00	-
Татварын өр	3,933,486.72	76,950,845.23
Урьдчилж олсон орлого	340,308,035.73	1,209,946,294.60
Богино хугацаат өглөгийн дүн	647,037,907.91	1,502,013,462.49
Өр төлбөрийн нийт дүн	647,037,907.91	1,502,013,462.49
Эздийн өмч	2,821,123.00	2,821,123.00
Өмч: -төрийн	2,821,123.00	2,821,123.00
Эздийн өмчийн бусад хэсэг	610,304,759.30	610,304,759.30
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	101,641,596.38	484,922,212.45
Тайлант үеийн үр дүн	-	383,280,616.07
Өмнөх үеийн үр дүн	101,641,596.38	101,641,596.38
Эздийн өмчийн дүн	714,767,478.68	1,098,048,094.75
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,361,805,386.59	2,600,061,557.24

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Байгууллагын нэр: БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛ
ТӨААТҮГ

2017 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар		/Төгрөгөөр/	
Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31	
Борлуулалтын орлого (цэвэр)	1,149,052,463.62	176,927,844.29	
Борлуулалтын өртөг	1,074,565,849.08	-	
Нийт ашиг (алдагдал)	74,486,614.54	176,927,844.29	
Хүүгийн орлого	44,254,035.91	20,774,526.61	
Бусад орлого	383,449,980.42	659,563,898.99	
Ерөнхий ба удирдлагын зардал	484,198,527.38	329,998,880.90	
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдал	3,017,435.49	91,263,483.43	
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	14,974,668.00	436,003,905.56	
Орлогын татварын зардал	5,922,869.00	52,723,289.49	
Татварын дараах ашиг алдагдал	9,051,799.00	383,280,616.07	
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	9,051,799.00	383,280,616.07	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Байгууллагын нэр: БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН НЭГДЭЛ ТӨААТҮГ

2017 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	ЭЗДИЙН ӨМЧИЙН	ХУРИМТДЛАГДСАН АШИГ	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН
2016 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,821,123.00	560,649,103.30	154,456,011.65	717,926,237.95
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(61,866,214.26)	(61,866,214.26)
Талант үеийн цэвэр ашиг (Алдагдал)			9,051,798.99	9,051,798.99
Өмчид гарсан өөрчлөлт		49,655,656.00		49,655,656.00
Зарласан ногдол ашиг				-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,821,123.00	610,304,759.30	101,641,596.38	714,767,478.68
Талант үеийн цэвэр ашиг (Алдагдал)			383,280,616.07	383,280,616.07
Бусад орлого				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Зарласан ногдол ашиг				-
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,821,123.00	610,304,759.30	484,922,212.45	1,098,048,094.75

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.4 Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан**Байгууллагын нэр: БАТЛАН ХАМГААЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН
НЭГДЭЛ ТӨААТҮГ**

2017 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31	2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	7,954,110,862.81	1,552,257,481.52
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	55,997,080.00	190,200,781.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	11,933.32	650,000.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	45,260,058.00
Буцаан авсан албан татвар	-	30,000.00
Татаас, санхүүжилтийн орлого	1,090,467,848.00	790,150,496.00
Бусад мөнгөн орлого	6,807,634,001.49	525,966,146.52
Мөнгөн зарлагын дүн (-)	8,677,127,891.23	1,403,063,609.85
Ажилчдад төлсөн	208,708,652.55	149,283,296.57
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	55,072,096.69	23,829,421.14
Бараа материал худалдан авахад төлсөн	81,688,516.00	54,233,619.00
Ашиглалтын зардалд төлсөн	23,595,474.20	26,281,758.49
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,110,896.00	7,136,860.00
Татварын байгууллагад төлсөн	64,210,354.34	38,230,054.40
Даатгалын төлбөрт төлсөн	5,050,500.00	4,788,711.27
Бусад мөнгөн зарлага	8,231,691,401.45	1,099,279,888.98
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(723,017,028.42)	149,193,871.67
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(723,017,028.42)	149,193,871.67
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,178,549,814.00	455,532,785.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	455,532,785.46	604,726,657.13

